

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
БХС	Батлан хамгаалахын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.24 № 08/467
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол цэргийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол цэргийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төвийн гүйцэтгэлд материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Монгол цэргийн музейн бие бүрэлдэхүүн нь тайлант 2020 онд "Монгол цэргийн музей-2020" хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлаа "Бүрэн" хангалттай биелүүлсэн гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

\\10.10.10.20\Bichig_Khereel\Yawsan_Bichig\2021\0224audit\4-R_Gazar2.Docx

001020006

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Я.САМБУУНЯМ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,312,046.35	40,932,818.55
35	БАРАА МАТЕРИАЛ	34,312,046.35	40,932,818.55
354	Хангамжийн материал	34,312,046.35	40,932,818.55
35410	Бичиг хэргийн материал	1,855,889.00	1,858,108.00
35420	Аж ахуйн материал	2,508,480.00	2,851,568.00
35440	Түлш, шатах тослох материал	-	30,000.00
35450	Барилгын засварын материал	5,040,200.00	7,559,425.00
35470	Бусад хангамжийн материал	24,907,477.35	28,633,717.55
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,235,734,641.51	5,145,092,573.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,235,734,641.51	5,145,092,573.43
392	Биет хөрөнгө	5,205,692,181.51	5,115,085,113.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,536,855,897.40	3,561,881,897.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(118,236,175.14)	(220,126,676.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	97,279,475.24	98,689,175.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,826,997.67)	(67,487,378.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,515,242.33	95,487,069.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,166,652.15)	(52,178,366.31)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,691,182,672.55	1,691,730,672.55
39217	Ном	7,088,718.95	7,088,718.95
393	Биет бус хөрөнгө	30,042,460.00	30,007,459.96
39301	Програм хангамж	1,120,000.00	1,120,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(805,000.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,692,460.00	29,692,460.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,270,046,687.86	5,186,025,391.98
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,270,046,687.86	5,186,025,391.98
51	Засгийн газрын хувь оролцоо	5,270,046,687.86	5,186,025,391.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,239,669,238.14	1,239,669,238.14
51101	Өмч: - төрийн	1,239,669,238.14	1,239,669,238.14
512	Хуримтлагдсан үр дүн	(529,527,183.06)	(613,548,478.94)
51210	Өмнөх үеийн үр дүн	(529,527,183.06)	(529,527,183.06)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(84,021,295.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,559,904,632.78	4,559,904,632.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,270,046,687.86	5,186,025,391.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	475,170,095.00	560,455,813.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,418,075.00	16,772,213.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,418,075.00	16,772,213.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,418,075.00	16,772,213.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,687,000.00	5,405,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,781.00	7,088,453.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,575,294.00	4,278,760.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	438,752,020.00	543,683,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,420,500.00	543,683,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	409,420,500.00	543,683,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	531,838,861.01	644,356,592.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,838,861.01	644,356,592.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,824,445.66	620,508,812.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,748,500.00	402,002,980.05
210101	Үндсэн цалин	268,261,337.00	271,204,180.05
210102	Нэмэгдэл	39,353,663.00	101,328,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,133,500.00	29,470,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,598,739.59	44,276,550.65
210201	Тэтгэврийн даатгал	23,504,151.59	27,140,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,768,000.00	4,360,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,038,572.00	3,372,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	620,820.00	988,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,667,196.00	8,416,150.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,515,227.30	25,006,760.24
210301	Гэрэл, цахилгаан	7,969,219.00	7,375,246.00
210302	Түлш, халаалт	15,070,923.65	16,499,587.24
210303	Цэвэр, бохир ус	1,475,084.65	1,131,927.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,384,530.76	7,871,934.00
210401	Бичиг хэрэг	3,038,097.00	1,905,332.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	1,825,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,279,184.76	1,105,261.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,010,000.00	1,343,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	557,249.00	630,512.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,062,628.80
2105	Нормативт зардал	80,000.00	130,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	80,000.00	130,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,999,260.00	10,985,475.00
210604	Урсгал засвар	16,999,260.00	10,985,475.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,627,021.00	8,549,101.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,580,103.00	2,075,983.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,995,068.00	5,983,118.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,462,850.00	150,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,589,000.00	340,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,571,167.01	121,686,011.31
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,571,167.01	121,686,011.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,014,415.35	23,847,779.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,742,800.00	20,728,260.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,382,860.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,742,800.00	1,345,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,271,615.35	3,119,519.86
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,271,615.35	3,119,519.86

Монгол цэргийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(56,668,766.01)	(83,900,779.11)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	557,625.00	120,516.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	557,625.00	120,516.77
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(557,625.00)	(120,516.77)
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(57,226,391.01)	(84,021,295.88)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	453,133,201.00	556,177,053.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,842,781.00	12,493,453.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,842,781.00	12,493,453.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,842,781.00	12,493,453.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,687,000.00	5,405,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,781.00	7,088,453.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,290,420.00	543,683,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,420,500.00	543,683,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	409,420,500.00	543,683,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	440,483,201.00	529,243,353.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	440,483,201.00	529,243,353.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,468,785.65	505,395,573.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	321,748,500.00	402,002,980.05
210101	Үндсэн цалин	243,676,312.00	271,204,180.05
210102	Нэмэгдэл	58,813,188.00	101,328,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,259,000.00	29,470,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,506,638.59	44,276,550.65
210201	Тэтгэврийн даатгал	23,412,050.59	27,140,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,768,000.00	4,360,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,038,572.00	3,372,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	620,820.00	988,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,667,196.00	8,416,150.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,515,227.30	25,006,760.24
210301	Гэрэл, цахилгаан	7,969,219.00	7,375,246.00
210302	Түлш, халаалт	15,070,923.65	16,499,587.24
210303	Цэвэр, бохир ус	1,475,084.65	1,131,927.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,238,498.76	7,654,481.20
210401	Бичиг хэрэг	2,908,765.00	2,657,820.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	1,855,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,279,184.76	1,105,261.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,010,000.00	1,358,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	540,549.00	678,200.00
2105	Нормативт зардал	130,000.00	130,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	130,000.00	130,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,995,200.00	13,762,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	315,500.00
210604	Урсгал засвар	16,995,200.00	13,447,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,034,721.00	12,562,101.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,580,103.00	2,335,383.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,995,068.00	5,983,118.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,462,850.00	227,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,996,700.00	4,016,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,014,415.35	23,847,779.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,742,800.00	20,728,260.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	19,382,860.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,742,800.00	1,345,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,271,615.35	3,119,519.86

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,271,615.35	3,119,519.86
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,650,000.00</u>	<u>26,933,700.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,650,000.00	26,933,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,650,000.00	26,933,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,650,000.00	26,933,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,650,000.00	26,933,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(12,650,000.00)</u>	<u>(26,933,700.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	_____ -	_____ -
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,239,669,238.14	4,559,904,632.78	(472,300,792.05)	5,327,273,078.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,239,669,238.14	4,559,904,632.78	(472,300,792.05)	5,327,273,078.87
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(57,226,391.01)	(57,226,391.01)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,239,669,238.14	4,559,904,632.78	(529,527,183.06)	5,270,046,687.86
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,239,669,238.14	4,559,904,632.78	(529,527,183.06)	5,270,046,687.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,239,669,238.14	4,559,904,632.78	(529,527,183.06)	5,270,046,687.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(84,021,295.88)	(84,021,295.88)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,239,669,238.14	4,559,904,632.78	(613,548,478.94)	5,186,025,391.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	553,683,600.00	553,057,533.14	626,066.86	99.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553,683,600.00	553,057,533.14	626,066.86	99.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	532,955,300.00	532,329,273.14	626,026.86	99.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,006,000.00	402,002,980.05	3,019.95	100.00
210101	Үндсэн цалин	271,207,200.00	271,204,180.05	3,019.95	100.00
210102	Нэмэгдэл	101,328,800.00	101,328,800.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,470,000.00	29,470,000.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,614,300.00	44,276,550.65	337,749.35	99.24
210201	Тэтгэврийн даатгал	27,140,400.00	27,140,400.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,360,000.00	4,360,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,372,000.00	3,372,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	988,000.00	988,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,753,900.00	8,416,150.65	337,749.35	96.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,262,700.00	25,006,760.24	255,939.76	98.99
210301	Гэрэл, цахилгаан	7,549,600.00	7,375,246.00	174,354.00	97.69
210302	Түлш, халаалт	16,499,600.00	16,499,587.24	12.76	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,213,500.00	1,131,927.00	81,573.00	93.28
2104	Хангамж, бараа материалын зардал	7,661,700.00	7,654,481.20	7,218.80	99.91
210401	Бичиг хэрэг	2,657,900.00	2,657,820.00	80.00	99.99
210402	Тээвэр, шатахуун	1,855,500.00	1,855,000.00	500.00	99.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,111,900.00	1,105,261.20	6,638.80	99.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,358,200.00	1,358,200.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	678,200.00	678,200.00	-	100.00
2105	Нормативт зардал	130,000.00	130,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	130,000.00	130,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,249,000.00	40,248,400.00	600.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,949,900.00	8,949,600.00	300.00	99.99
210604	Урсгал засвар	31,299,100.00	31,298,800.00	300.00	99.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,031,600.00	13,010,101.00	21,499.00	99.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,336,000.00	2,335,383.00	617.00	99.97
210803	Даатгалын үйлчилгээ	6,000,000.00	5,983,118.00	16,882.00	99.72
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	445,600.00	441,600.00	4,000.00	99.10
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,250,000.00	4,250,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,728,300.00	20,728,260.00	40.00	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,728,300.00	20,728,260.00	40.00	99.99
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,382,900.00	19,382,860.00	40.00	99.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,345,400.00	1,345,400.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	553,683,600.00	553,057,533.14	626,066.86	99.89
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	543,683,600.00	540,564,080.14	3,119,519.86	99.43
131001	Улсын төсвөөс санхүүжих	543,683,600.00	540,564,080.14	3,119,519.86	99.43
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,000,000.00	12,493,453.00	(2,493,453.00)	124.93

Монгол цэргийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	5,405,000.00	4,595,000.00	54.05
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	7,088,453.00	(7,088,453.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.00	36.00	-	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	-	-
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	-	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол цэргийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал, хурандаа Д.Ганзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, авлага болон борлуулалтын орлогыг зөв бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 06-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Д.Мөнхтуяа, Г.Баяржаргал, Г.Төрсайхан нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол цэргийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол цэргийн музейн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Монгол төр, ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө баатарлаг гавьяа байгуулсан үе үеийн эрэлхэг хөвгүүдийн тэмцлийн яндашгүй түүхийг ард иргэдэд таниулах, цэргийн түүхэнд холбогдох эд өлгийн хайгуул, судалгаа хийж, сурвалжлан олох, хадгалж хамгаалах, судлах, дэлгэн үзүүлэх, Монголын төрийн батлан хамгаалах бодлого шийдвэрийг сурталчлан таниулахад оршино. Үүнд:

- Монгол цэргийн түүхийг судлах, түүнтэй холбоотой эд өлгийн цуглуулга хийх, хадгалалт, хамгаалалт, сурталчилгаа явуулах, сэргээн засварлалт хийх ашгийн төлөө бус олон нийтэд үйлчлэх явдал юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 2019 оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу Батлах хамгаалах яамны сайдын А/270 дугаар тушаалаар баталсан НБББББ-ийн өөрчлөлт;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар даатгуулагч болон ажил олгогчоос төлөх шимтгэлийн өөрчлөлт;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт орсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Монгол цэргийн музей нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Батлан хамгаалах яамны салбарын хэмжээний нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Монгол цэргийн музейн үзвэрийн тасалбар /үнэт цаас/-ыг бараа материалын ангилалд ямар дансанд бүртгэх болон хяналт тавих талаар тусгаагүй байна.

Монгол Цэргийн музейн дотоод хяналт шалгалтын нэгж нь 2020 онд байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус үзлэг шалгалтыг хийж, 143.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэн байна.

Тухайн шалгалтаар ажилчдын цалинг цаг тухай бүрт нь бодож олгосон боловч зарим хүмүүсийн цалинг буруу бодсон, цалингаас суутгах ёстой суутгалыг тухай бүрд нь суутгаж байгаагүй, програмаас цалинг хөрвүүлэх явцад илүү болон дутуу таталт хийгдсэн зэрэг зөрчил илэрсэн байна. Музейн захирлын 2020 оны Б/07 дугаар тушаалаар ерөнхий нягтлан бодогчид сахилгын сануулах арга хэмжээ авч, зөрүүтэй бодсон 143.2 мянган төгрөгийг төлүүлсэн байна.

Монгол цэргийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 644,477.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12,889.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол цэргийн музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,021.3 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	34,312.0	40,932.8	6,620.8
Үндсэн хөрөнгө	5,235,734.6	5,145,092.5	(90,642.1)
Нийт хөрөнгө	5,270,046.6	5,186,025.3	(84,021.3)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,270,046.6	5,186,025.3	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,270,046.6	5,186,025.3	(84,021.3)

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,932.8 мянган төгрөг болж 6,620.8 мянган төгрөгөөр өссөн нь боловсролын өрөө шинээр тохижуулах санхүүжилт 2020 оны эцсээр шийдэгдэж материалаа худалдан авсан боловч цар тахлын улмаас тохижилтын ажил бүрэн хийгдээгүй материалын үлдэгдэлтэй байна. Мөн Эрүүл мэндийн яамнаас ирсэн зөвлөмжийн дагуу тусгаарлах өрөө гаргаж, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, цэвэрлэгээний бодис авсан зэрэг нь үлдэгдэл нэмэгдэх шалтгаан болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,145,092.5 мянган төгрөг болж 90,642.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл болон үндсэн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 26,933.7 мянга, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4,230.7 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, Батлан Хамгаалахын Сайдын 2020 оны А/306 дугаар тушаалаар 2,208.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассан болон уг хөрөнгийн тооцогдсон элэгдэл 2,088.4 мянга, тайлант онд байгуулсан 121,686.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлээр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,186,025.3 мянган төгрөг болж 84,021.3 мянган төгрөгөөр буурсан нь нийт хөрөнгийн хэмжээ буурснаас шалтгаалжээ. Энэ нь тайлант оны элэгдлийн зардал болон үндсэн хөрөнгө данснаас хассантай холбоотой байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 85,285.7 мянган төгрөгөөр буюу 17.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүжилтийн орлого байна. Энэ нь цалингийн өсөлт болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урсгал санхүүжилтээр хийгдэх ёстой их засварын хоёр ажил төсөвлөгдөж нэмэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 112,517.7 мянган төгрөгөөр буюу 21.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ажилчдын цалин, шимтгэлийн зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, их засварын зардлууд байна.

Энэ нь тайлант онд төсвийн байгууллагын ажилчдын цалинг 8-32 хувиар нэмэгдүүлсэн, үндсэн хөрөнгө шинээр худалдан авснаас элэгдлийн зардал нэмэгдсэн, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон, их засварын хоёр ажил хийгдсэн зэрэгтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг болон нийт зарлагыг 607,193.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 607,193.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Батлан хамгаалахын сайдын А/321 дугаар тушаалаар 2020 оны 12 дугаар сарын 31-нд Монгол цэргийн музейн 2020 оны тодотгосон төсвийн хуваарийг батлахдаа зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 553,683.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 553,683.6 мянган төгрөг байхаар тооцож төсвийг 53,510.3 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг хөтөлбөр, дөрвөн арга хэмжээг санхүүжүүлэхээр 553,683.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 543,683.6 мянган төгрөгийг улсын төсвөөс 10,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 543,683.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,405.0 мянга, түрээсийн орлогоос 6,777.0 мянга, бусад орлогоос 311.4 мянга, нийт 556,177.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 553,057.5 мянган төгрөгийг зарцуулж 3,119.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 553,057.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалингийн зардал 3.0 мянга, хоёр албан хаагч нэг нь тэтгэвэрт гарсан, нэг нь групп тогтоолгосноос нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн код солигдсонтой холбоотой эрүүл мэндийн даатгалын зардал 337.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 255.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цар тахлын улмаас байгууллагын нийт бие бүрэлдэхүүний 70 хувь нь цахимаар ажил үүрэг гүйцэтгэсэн учраас ус, цахилгааны ашиглалт дутуу зарцуулагдсан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 21.5 мянга, хангамж бараа материалын зардал 7.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь цар тахлаас үүдэн Жуковын музей нь ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 10,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,405.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөөний биелэлт 54.0 хувьтай байна. Туслах үйл ажиллагаа буюу түрээсийн орлого 6,777.0 мянга, бусад орлогоор 311.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого /музейн үзмэрийн орлого/	10,000.0	5,405.0	(4,595.0)	54%
Туслах үйл ажиллагаа /түрээсийн орлого/	-	6,777.0	6,777.0	
Туслах үйл ажиллагаа /бусад орлого/	-	311.4	311.4	
Нийт дүн	10,000.0	12,492.4	2,493.4	124.9%

Үндсэн үйл ажиллагааны орлого 4,595.0 мянган төгрөгөөр буюу 46.0 хувиар тасарсан нь улс орны хэмжээнд Ковид-19 цар тахал болж хөл хорио тогтоосноос музей ажиллаагүйтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Монгол цэргийн музей нь 2020 онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байгаа боловч оруулсан мэдээлэл үнэн зөв байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,820.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн. Зөвлөмж 100 хувь хэрэгжсэн гэж үзэж байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	5,820.0	4	5,820.0	-	-	100%
Нийт дүн	4	5,820.0	4	5,820.0	-	-	100%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 651.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг, арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

1. Монгол цэргийн музейн сан хөмрөгийн програмд бүртгэгдсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээллийг, санхүүгийн пр

ограм дах түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн мэдээлэлтэй тулган шалгах, тэдгээрийн дахин үнэлгээний дүнг нягталж шалгах;

2. Төсвийн төвлөрүүлэн захирагч төсвийн тодотголыг тайлант оны сүүлийн өдөр тухайн байгууллагын бүрдүүлсэн орлого болон зарцуулсан зардлын гүйцэтгэлээр нь тодотгож байна гэж үзэхээр байна.

3. Мөн дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагын үндсэн хөрөнгө болон эд өлгийн зүйлд биет шалгалт хийгээгүй ба тухайн байгууллагын аудитад өгсөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас түүвэрлэн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч нөхөн сэргээж цаашид ашиглах шаардлагатай хөрөнгүүд байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: Шилэн дансны мэдээллийг шалгахад мэдээллээ бүрэн байршуулсан боловч 2020 оны тайлант хугацаанд 2 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

4.1.2 Эрсдэл: Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байх;

4.1.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалтыг хэрэгжүүлж ажиллах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Цаашид хэрэгжүүлж ажиллана.

4.2 Балансын данстай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт: Тайлант онд гэрээний дагуу төвлөрүүлэх түрээсийн орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс 651.0 мянган төгрөгийн тооцооны үлдэгдлийг санхүүгийн тайланд орлого болон авлагаар тусгаж тайлагнаагүй байна.

4.2.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

4.2.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, Эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Цаашид нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: “Өөдрөг өнгө” ХХК нь Цар тахлын үед үйл ажиллагаа явуулахгүй байгаа, түрээсийн хөнгөлөлт үзүүлэх боломж байна уу гэсэн санал тавьсан бөгөөд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн байсан тул саналыг захирлын зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлэх боломжгүй байсан. Өөдрөг өнгө ХХК төлбөрийн үлдэгдлийг 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр төлснийг 2021 оны 1 дүгээр сарын тайланд тусгасан.

4.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт: Батлан хамгаалах яамны салбарын хэмжээний нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Монгол цэргийн музейн үзвэрийн тасалбар /үнэт цаас/-ыг бараа материалын ангилалд ямар дансанд бүртгэх болон хяналт тавих талаар тусгаагүй байна. Мөн уг тасалбар нь кассын нярвын хариуцлаганд байдаг ба нярав өөрөө борлуулдаг байна.

4.3.2 Эрсдэл: Хөрөнгө, мөнгө дутагдах эрсдэлтэй

4.3.3 Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн Сайдын 2012 оны 294 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 4.1.9-д “Үнэт цаас, тооцоот маягыг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хэвлүүлж, түүний хадгалалт, зарцуулалтад хяналт тавих” заалттай нийцэхгүй байна.

Цаашид өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан НБББББ-т нэмэлт оруулах, үзвэрийн тасалбарыг кассын нярваас өөр хүнд хариуцуулах

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.4 Балансын данстай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт: Тус байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын дэлгэрэнгүй тайланг шалгахад ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө, бараа материалууд байна. Мөн 2020 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлээр цаашид ашиглах, нөхөн сэргээх боломжгүй 33 нэр төрлийн үндсэн хөрөнгө болон бараа материал бүртгэлтэй байна.

4.4.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан, мэдээ буруу илэрхийлэгдэх

4.4.3 Өгсөн зөвлөмж: УСНББОУС 17-н 82 дугаар заалтын дагуу цаашид ашиглах боломжгүй 33 нэр төрлийн хөрөнгийн асуудлыг холбогдох дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгийг цаашид ашиглах хугацааг нь тогтоолгож үнэлүүлэх.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана. Цаашид ашиглах боломжгүй 33 нэр төрлийн хөрөнгийг данс бүртгэлээс хасуулах, үнэлэгдэх боломжтой хөрөнгийг үнэлж, данс бүртгэлд тусгах талаар дээд шатны байгууллагад санал хүргүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.17	Аудитын нэр: Монгол Цэргийн Музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/346/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Монгол Цэргийн Музей	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны мэдээллийг шалгахад мэдээллээ бүрэн байршуулсан боловч 2020 оны тайлант хугацаанд 2 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Алтантуяа
2	Тайлант онд түрээсийн орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс 651.0 мянган төгрөгийн тооцооны үлдэгдлийг санхүүгийн тайланд орлого болон авлагаар тусгаж тайлагнаагүй байна.	651.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Алтантуяа
3	Батлан хамгаалах яамны салбарын хэмжээний нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Монгол цэргийн музейн тоглолтын билет /үнэт цаас/-ыг бараа материалын ангилалд ямар дансанд бүртгэх болон хяналт тавих талаар тусгаагүй байна. Мөн уг тасалбар нь кассын нярвын хариуцлаганд байдаг ба нярав өөрөө борлуулдаг байна.		Зөвлөмж	Нягтлан бодогч	Ц.Алтантуяа
4	Тус байгууллагын үндсэн хөрөнгө бараа материалын дэлгэрэнгүй тайланг шалгахад ашиглалтын хугацаа дуусч элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгө, бараа материалууд байна. Мөн 2020 оны жилийн эцсийн тооллогын бүртгэлээр цаашид ашиглах, нөхөн сэргээх боломжгүй 33 нэр төрлийн үндсэн хөрөнгө болон бараа материал бүртгэлтэй байна.		Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Д.Ганзориг Ц.Алтантуяа
ДҮН		651.0			